

# “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04-р сарын 17-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

## “СҮҮ” ХК-ИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын №02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн эхийг Хавсралтаар баталсугай.

2. “Сүү” ХК-ийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /М.Мандхай/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

“Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын  
2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн  
№01 тоот Тогтоолын хавсралт №1

“СҮҮ” ХК-ИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



№	Одоогийн заалт	Нэмэлт өөрчлөлт орсны дараа
1.	3.2. Компани нь үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ болон бусад хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа явуулна.	3.2. Компани нь <u>сүү сүүн бүтээгдэхүүний</u> үйлдвэрлэл, худалдаа, <u>сүүний тээврийн</u> үйлчилгээ болон бусад хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа явуулна.
2.	4.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 344,000,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.	4.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 429,589,000 ширхэг энгийн хувьцаа байна.
3.	4.2. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 344,000,000 ширхэг энгийн хувьцаа байна.	4.2. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь <u>34,400,000 (Гучин дөрвөн сая дөрвөн зуун мянга) төгрөг байх бөгөөд</u> нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 344,000,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
4.	4.5. Жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс бага болсон тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл нь ийнхүү бага болсон шалтгааныг судлан, дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах /хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар/ тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлнэ. Хэрвээ ийнхүү бага болсон нь алдагдалтай ажилласанаас шалтгаалсан бөгөөд дахин хөрөнгөжүүлэх, хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар шийдвэрлэх боломжгүй бол компанийг татан буулгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.	4.5. Жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс бага болсон тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл нь ийнхүү бага болсон шалтгааныг судлан, дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах /хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар/ тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан хэлэлцүүлнэ. Хэрвээ ийнхүү бага болсон нь алдагдалтай ажилласнаас шалтгаалсан бөгөөд дахин хөрөнгөжүүлэх, хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар шийдвэрлэх боломжгүй бол компанийг татан буулгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
5.	4.10. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж хөрөгдуулж болно: 4.10.1. хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх; 4.10.2. хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөлгүйгээр хувьцааг хуваах эсхүл	4.10. <u>Компани</u> хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах <u>үндэслэлээр өөрчилж</u> болно: 4.10.1. <u>нэгж</u> хувьцааны нэрлэсэн үнийг <u>өсгөх, эсхүл бууруулах</u> ; 4.10.2. <u>хувьцаа нэмж гаргах замаар өсгөх</u> ; 4.10.3. өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн

	нэгтгэх; 4.10.3. хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох.	<u>худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.</u>
6.	5.8.Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх /дийлэнхи олонхиор/ дараах асуудлыг шийдвэрлэнэ./	<u>Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх 5.8.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг шийдвэрлэнэ:</u>
7.		5.8 <sup>1</sup> Энэхүү дүрмийн 5.8.1-5.8.6, 5.8.8-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор, ТУЗ-ын гишүүдийг сонгохоос бусад асуудлыг саналын олонхиор, ТУЗ-ын гишүүдийг сонгох асуудлыг кумулятив аргаар тус тус шийдвэрлэнэ.
8.		<u>5.20. Компани цахимаар санал авах цахим программыг хөгжүүлж, ашиглах талаар зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно. Энэ тохиолдолд хуралд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой программыг бүтээх үүргийг мэдээллийн технологийн компани хүлээнэ. Түүнчлэн мэдээллийн технологийн компани нь энэхүү үүргээ баталгаажуулсан албан бичгийг компанид хүлээлгэж өгнө.</u>
9.	6 Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар Нэмж гаргаж буй хувьцааг төдөрхөй хөрөнгө оруулагчдад төдөрхөй гэрээний дагуу эзэмшүүлэхээр гаргаж байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэсэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуралд оролцож буй саналын эрхийн дийлэнх олонхийг эзэмшигчдийн саналаар шийдвэрлэж болно	<u>6.2.6<sup>1</sup> Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар Нэмж гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэсэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуралд оролцож буй саналын эрхийн дийлэнх олонхийг эзэмшигчдийн саналаар шийдвэрлэж болно.</u>
10.	8.3. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 4-жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжлэнэ.	8.3. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь <u>2 (хоёр) жил байх бөгөөд хэдэн ч удаа улируулан сонгож болно.</u>
11.	8.5.6. Компани болон түүний хараат, өхин компани, компанид нэгдэлд хамаарах компанийн нэгдэлд сүүлийн 1 жилийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан болон бусад албан тушаалд ажиллаж байгаагүй;	8.5.6. <u>Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;</u>
12.	8.14. ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан	<u>ТУЗ-ийн хурал</u> 8.14. ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай

	хуралдуулж болно.	тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно. <u>ТУЗ-ийн хурлыг видео конференци хэлбэрээр, эсхүл ТУЗ-ын гишүүдийн албан ёсны цахим хаягаар мэдээлэл солилцох хэлбэрээр саналыг нь авах замаар эчнээ хэлбэрээр явуулж болно. ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нар ийнхүү цахим, эсхүл эчнээ хэлбэрээр хуралдуулахдаа ТУЗ-ийн гишүүдийг тухайн хуралд оролцох, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, санал хураалтанд оролцох боломжоор хангаж ажиллана.</u>
13.	10.4. Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтлөх бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалсан байх нь гүйцэтгэх захирлын хариуцах асуудал болно:	10.4. Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтлөх бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох <u>баримт бичгийг зохих журмын дагуу хадгалсан байх нь ТУЗ-ын нарийн бичгийн даргын хариуцах асуудал болно:</u>
14.	11.5. Нөгдөл ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.	11.5. <u>Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.</u>
15.	11.7. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банк дах дансанд шилжүүлэх бодлого баримтална.	11.7. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө. Ногдол ашгийг <u>ҮЦТХТ ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн ҮЦТХТ ХХК дахь дансанд шилжүүлэх бодлого баримтална.</u>

# “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04-р сарын 17-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

## 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Сүү” ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын №02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

# “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04-р сарын 17-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА НЭМЖ ГАРГАХ, ХУВЬЦАА НЭМЖ ГАРГАХ ТӨСЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, “Сүү” ХК-ийн дүрмийн 4 болон 5 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын №02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн сүү хүлээн авах хэсэг болон боловсруулах үйлдвэрийг автоматжуулан Олон улсын ISO 22000 стандартыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн зардлыг бууруулан, үйлдвэрлэлийн бүтээмж, хэмжээг тогтвортой нэмэгдүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулан, зорилтот зах зээл дэх байр суурийг нэмэгдүүлэх зорилгоор 85,589,000 /Наян таван сая таван зуун наян есөн мянга/ ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгон нэмж гаргасугай.

2. “Сүү” ХК-ийн “Хувьцаа нэмж гаргах” төслийг Хавсралтаар баталсугай.

3. “Сүү” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцаа нь компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохгүй тул хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх шаардлага үүсэхгүй болохыг дурдсугай.

4. Нэмж гаргаж буй хувьцааны нийтэд санал болгох үнэ, хувьцаа нэмж гаргахтай холбоотой аливаа асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажиллах бүрэн эрхийг “Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.

5. “Сүү” ХК-ийн хувьцаа нэмж гаргах, нэмж гаргаж буй хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д бүртгүүлэхтэй холбоотой мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулах, харилцах ажлыг шуурхай зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /М.Мандхай/-д үүрэг болгосугай.

6. Нэмж гаргасан хувьцааг зохих журмын дагуу бүртгүүлэн, олон нийтэд санал болгон амжилттай арилжсан тохиолдолд компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцүүлэхээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал товлон хуралдуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ



“Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын  
2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн  
№03 тоот Тогтоолын хавсралт №1



## “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА НЭМЖ ГАРГАХ ТӨСӨЛ

### 1. Төслийн зорилго:

1.1. Энэхүү төслийн зорилго нь “Сүү” ХК-ийн сүү хүлээн авах хэсэг болон боловсруулах үйлдвэрийг автоматжуулан Олон улсын ISO 22000 стандартыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн зардлыг бууруулан, үйлдвэрлэлийн бүтээмж, хэмжээг тогтвортой нэмэгдүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулан, зорилтот зах зээл дэх байр суурийг нэмэгдүүлэхээр Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа нэмж гаргах шийдвэр гаргах, түүнтэй холбоотойгоор үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Төсөл хэрэгжүүлэгч буюу үнэт цаас гаргагчийн нэр: “Сүү” ХК,

1.3. Үнэт цаас гаргагчийн хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37, өөрийн байр,

1.4. Компанийн тухай хуулийн 62.1.3-д заасны дагуу “Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн, компанийн тухай хуулийн 63.7-д “Энэ хуулийн 62.1.1-62.1.6-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ” гэж заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд нэмж хувьцаа гаргах төслийг танилцуулж байна.

### 2. Төслийн ач холбогдол:

2.1. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр: Үйлдвэрийн сүү хүлээн авах хэсэг болон боловсруулах үйлдвэрийг автоматжуулан Олон улсын ISO 22000 стандартыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн зардлыг бууруулан, үйлдвэрлэлийн бүтээмж, хэмжээг тогтвортой нэмэгдүүлэн, зорилтот зах зээлийн хэрэгцээг чанартай бүтээгдэхүүнээр найдвартай хангах. Үүнд:

- 2.1.1. Сүү хүлээн авах, нөөцлөх хүчин чадлыг 2.5 дахин нэмэгдүүлэх,
- 2.1.2. Үйлдвэрлэлийн тогтмол өсөлттэй уялдан боловсруулах хэсгийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх,
- 2.1.3. Эрчим хүч, энергийн зарцуулалтыг 20% - 25%-иар бууруулах,

2.2. Экспорт хийх: Тоног төхөөрөмжийн шинэчлэл, автоматжуулалтыг хийж, Олон улсын ISO 22000 стандартыг нэвтрүүлснээр сүү, сүүн бүтээгдэхүүний экспорт хийх суурь нөхцөл бүрдэх,

2.3. Санхүү: Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх,

2.4. Засаглал: Хувьцаа нэмж гаргаснаар хувьцааны төвлөрөл буурах,

### **3. Төслийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэх стратеги:**

3.1. Үйлдвэрийн сүү хүлээн авах хэсэг болон боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг шинэчлэн, автоматжуулснаар Олон улсын ISO 22000 стандартыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, хяналт, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулж, үйлдвэрийн сүү хүлээн авах, нөөцлөх хүчин чадлыг 2.5 дахин, боловсруулах хэсгийн хүчин чадлыг 2 дахин тус тус нэмэгдүүлнэ.

3.2. Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдэд орчин үеийн технологийн шийдлийг нэвтрүүлснээр, эцсийн бүтээгдэхүүний хадгалах хугацааг уртасгах, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн зах зээлийн зорилтот хэрэглэгчдэд хүргэнэ.

3.3. Эрчим хүч, энергийн хэмнэлт гаргаснаар урсгал зардлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг явуулна.

3.4. Үйлдвэрийн бүрэн автоматжуулалт нь бүтээмжийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн дамжлагын цаг хугацааг хэмнэх, ажлын байранд үүсэх аливаа эрсдлийг бууруулна.

3.5. Хүнсний аюулгүй байдлыг хангасан, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх суурь нөхцөлийг хангана.

3.6. Компанид итгэх олон нийтийн итгэл нэмэгдэхээс гадна, үнэнч хэрэглэгчийн тоо өсөж, улмаар борлуулалт сайжирна.

3.7. Үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж ашигт ажиллагаа сайжирснаар хөрөнгө оруулагчдын хөрөнгийн өгөөж нэмэгдэнэ.

3.8. Хувьцаа нэмж гаргаснаар компанийн хувьцааны төвлөрөл буурч, компанийн засаглал одоо байгаагаас илүү сайжрах суурь нөхцөл бүрдэнэ.

### **4. Төслийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ:**

Үйлдвэрийн сүү хүлээн авах хэсэг болон боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг шинэчлэн, автоматжуулах төсөлд нийт 18,8 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа бөгөөд нэмж гаргах хувьцааны үнэ, тоо хэмжээ зэрэг нарийн мэдээлэл үнэт цаасны танилцуулга бэлэн болж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа нэмж гаргах асуудлыг хэлэлцэх үед тодорхой болох юм. Хэрэв нэмэлт хувьцаа гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ төслийн санхүүжилтийн дүнгийн хооронд аливаа зөрүү гарсан тохиолдолд зөрүү мөнгөн дүнг компани өөрийн үйл ажиллагааны ашгаас санхүүжүүлэх болно.

### **5. Компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, компанийн танилцуулга, үйл ажиллагааны тухай:**

#### **Алсын хараа:**

Монгол сүүгээр дэлхийг ундаална

#### **Эрхэм зорилго:**

Уламжлан ирсэн сүүн соёлыг орчин үеийн хэрэглээнд нийцүүлэн түгээнэ.


#### **Үнэт зүйлс:**

- Итгэл даасан чанар
- 60 жилийн туршлага
- Эрүүл хүнс
- Чадварлаг хамт олон
- Аюулгүй ажиллагаа



## Компанийн товч танилцуулга, үйл ажиллагаа:

Монгол улсын Ууган үйлдвэр "Сүү" ХК нь 1958 оноос хойш үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, нийслэл Улаанбаатар хот төдийгүй, хөдөө орон нутгийн хэрэглэгчдээ олон улсын стандарт шаардлагад нийцсэн экологийн цэвэр бүтээгдэхүүнээр ханган, нийт сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн 48%-ийг дангаар эзлэн, менежментийн мэргэжлийн багийн удирдлага дор эрхэм зорилго, алсын хараагаа баримтлан 400 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Манай компани хэрэглэгчдийнхээ нас, хэрэглээний онцлог, амьдралын хэв маягт нийцүүлэн, судалгаа шинжилгээний үндсэн дээр бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг жил бүр баяжуулан, зах зээлд манлайлагчийнхаа байр суурийг баттай хадгалсаар байгаа билээ.



Олон төрөл, зүйлийн эмийн ургамлаар хооллогч бэлчээрийн малын сүүгээр үйлдвэрлэсэн "Сүү" ХК-ийн бүтээгдэхүүнүүдэд Монгол хүний удмын дархлааг хадгалагч ашигт бактери агуулагдаж, элдэв өвчин эмгэгээс найдвартай хамгаалдаг ач тустай.

Ард иргэдээ чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан, монгол үнээний шимт сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангахын тулд бид хариуцлагаа ухамсарлан, цаг агаарын хүнд хэцүү ямар ч нөхцөлд, жилийн дөрвөн улиралд 2500 гаруй бэлтгэн нийлүүлэгчийнхээ хотноос сүүгээ шинээр нь татан авч, олон улсын стандарт шаардлагад нийцсэн техник, технологиор боловсруулан, байгаль орчинд ээлтэй сав боодол ашиглан, сүү, тараг, зайрмаг гэх мэт 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Мөн Улаанбаатар хот, хөдөө орон нутагт 2600 гаруй нэгжид бүтээгдэхүүний түгээлт хийн, харилцагчидтайгаа нягт хамтран ажиллаж байгаа билээ.

### Үйлдвэрлэлийн хүчин чадлын мэдээлэл:

- "Сүү" ХК-ийн үйлдвэр нь хоногт 120 тонн сүү хүлээн авч, боловсруулан сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.
- 2016 онд сүүг 135 хэмд ариутган уутанд савлах Элекстер шугамыг шинэчлэн, хоногт 56,000 ширхэг сүү үйлдвэрлэх хүчин чадал бүхий асептик EA4000 төхөөрөмжийг ашиглалтад оруулсан.
- Улаанбаатар хотын нийт сүүний хэрэглээний 74%-ийг хангаж буй "Миний Монголын сүү" брэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг АНУ-ын Нимко корпорацын 570 маркийн савлах төхөөрөмжтэй.
- Уламжлалт хэрэглээ болох "Элгэн тараг" брэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх технологийг 2015 онд дахин нэвтрүүлж, хэрэглэгчдэд хүргэж байна.
- 2016 онд Швед улсын Тетрапак компанийн цагт 6,000 ширхэг сүү савлах хүчин чадал бүхий асептик савлагааны бүрэн автомат шугам суурилуулсан. Тус шугам ашиглалтад орсноор Монгол улсад анх удаа бэлчээрийн үнээний сүүг ариутган 3 сар хадгалах технологийг нэвтрүүлсэн.
- Мөн тус компани нь 1985 онд Дани улсын Anhydro компанийн хоногт 40 тонн сүүг хатааж хуурайшуулах хүчин чадалтай хуурай сүүний үйлдвэрийг ашиглалтад оруулснаар зуны улиралд татан авсан хөдөө аж ахуйн сүүг хатаан боловсруулж, улмаар өвлийн улиралд шаардлагатай сүүний нөөцөө бэлтгэж байна.


- 1993 онд Япон улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар шинэчлэл хийгдсэн байгаль орчинд ээлтэй аммиакийн хөргөх байгууламжийг суурилуулсан.
- Түүхий эд болон бүтээгдэхүүн хадгалах зориулалттай, стандартын шаардлага хангасан 20,000 метр куб талбай бүхий хөргөлттэй агуулахтай.
- 2019 онд Франц улсын Серак компанийн Combox H2F маркийн ПЭТ савлагааны бүрэн автомат, 6,000 ширхэг/цаг хүчин чадалтай шугамыг ашиглалтад оруулан, хэрэглэхэд хялбар савлагаа бүхий “Амтлаг” тараг брэнд, мөн бүсгүйчүүдэд зориулсан эрүүл мэндийн бүтээгдэхүүн “Гоофит” брэндийг тус тус зах зээлд нэвтрүүлээд байна.
- Мөн 2019 онд ОХУ-ын Протемол компанийн хоногт 8,000 л сүү эздүүлэх хүчин чадалтай, битүү систем бүхий аарц үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг суурилуулсан.

### Зах зээлд эзлэх хувь 2019 оны байдлаар:



#1  
ТАРАГ

Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл нь сүүлийн жилүүдэд маш хурдацтайгаар бялуугаа томруулан тэлж байгаа бөгөөд “Апу дэйри” ХХК, “Витафит милк” ХХК, Тэсо групп зэрэг санхүүгийн хүчин чадал өндөртэй компаниуд энэхүү зах зээлд нэвтрэн орж, өрсөлдөөн улам бүр нэмэгдэж байна.



### “Сүү” ХК-ийн бизнесийн давуу тал:

“Сүү” ХК-ийн бизнесийн өрсөлдөх чадварын үндсэн үзүүлэлт нь “Бүтээгдэхүүний үнэнч хэрэглэгч” юм. Бүтээгдэхүүний чанар, 60 гаруй жилийн арвин туршлагад 100% итгэдэг, хэзээд үнэнч, тууштай Лоялти хэрэглэгчид маань компанийн үнэт зүйлийг бататгаж өгдөг.

## Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл, чиг хандлага:

Сүү, сүүн бүтээгдэхүүн нь Монгол хүний бие физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнд тооцогддог тул Стратегийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний ангилалд багтдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол улсад дэлхийн чиг хандлагын нэгэн адилаар жижиг талбайтай дэлгүүрийн загвар (CU, Circle K гэх мэт) трэнд болж байгаатай зэрэгцээд бүтээгдэхүүний төрлүүд хүртэл on-the-go (шууд хэрэглээний бүтээгдэхүүнүүд) хэрэглээ өсөн нэмэгдэж, нэг удаагийн хэрэгцээг хангах, хялбар, эко, бага савлагаа бүхий сүү, тараг, ааруул, холимог зууш зэрэг органик бүтээгдэхүүний хэрэглээ трэнд болж байна.

Үйлдвэрийн аргаар боловсруулсан энэ төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ цаашид жил бүр 10-12 хувиар нэмэгдэх хандлагатай гэсэн судалгаа байдаг. Энэ чиг хандлагад нийцүүлэн үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ чанаржуулах, шинэ төрөл зүйл нэмэн, олон сонголттойгоор зах зээлд нийлүүлэхийг хичээн ажиллаж байна.

Үүнээс гадна төр болон сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хувийн хэвшлүүд хамтран үндэсний аяныг өрнүүлж, сүүг шууд уух хэрэглээг хэвшүүлснээр зах зээл ахиад 2-3 дахин өсөх потенциалтай юм. 2005 оноос өмнөх он жилүүдэд Монгол улсад сүү, сүүн бүтээгдэхүүний задгай хэрэглээ болон импортын бүтээгдэхүүн давамгайл байсан бол өдгөө Үндэсний үйлдвэрлэл нийт зах зээлийн 91%-ийг эзэлж чадсан байна.

Өнөөдрийн байдлаар тараг, зөөхий, исэг ундааны төрлийн бүтээгдэхүүнүүд импортлогдон зах зээлд нийлүүлэгдэж байгаа хэдий ч, тэдгээр бүтээгдэхүүнүүд үнэ өндөр, хадгалах хугацаа урт байгаа зэрэг шалтгааны улмаас зах зээлд төдийлөн том байр суурь эзэлж чадахгүй, Үндэсний үйлдвэрлэгчид зах зээлдээ манлайлсан хэвээр байгаа юм.

Сүүлийн жилүүдэд томоохон сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн борлуулалтын хэмжээ биет болон мөнгөн дүнгээр тогтмол өсөж байна. "Сүү" ХК-ийн хувьд борлуулалтын орлого мөнгөн дүнгээр 2018 онд 22%, 2019 онд 5%-ийн өсөлтийг тус тус үзүүлээд байна.

## Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ:



### МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН 2020 ОНЫ ХҮНСНИЙ ХЭРЭГЦЭЭ

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн 1 хүний	Жишсэн хүн амын хүнсний	
		жилийн хэрэгцээ, кг	хэрэгцээ, мян,тн	2020*
	Жишсэн хүн амын тос (мян, хүн)		2019	2020*
			2613.3	2649.9
1	Малын мах	43.8	114.5	116.1
2	Загас	11.0	28.7	29.1
3	Шууны мах	14.6	38.2	38.9
4	Сүү	58.4	152.6	154.8
5	Сүүн бүтээгдэхүүн	65.7	171.7	174.1
6	Гурил	36.5	95.4	96.7
7	Гурилан бүтээгдэхүүн	65.7	171.7	174.1
8	Төрөл бүрийн будаа	18.3	47.8	48.5
9	Төмс	43.8	114.5	116.1
10	Хүнсний ногоо	94.9	248.0	251.5
11	Буурцагт ургамал	14.6	38.2	38.7
12	Жимс, жимсгэнэ	73.0	190.8	193.4
13	Өндөг	7.3	19.1	19.3
14	Ургамлын тос	8.4	22.0	22.3
15	Цэцгийн тос	3.7	9.7	9.8
16	Савхар, чихрийн зүйл	12.0	31.4	31.8

2020 оны хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг өмнөх онтой харьцуулбал сүү 2.2 мянган тонноор, бусад сүүн бүтээгдэхүүн 2.4 мянган тонноор тус тус нэмэгдэх төлөв харагдаж байна.

Монгол хүний сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд нэг хүнд ногдох сүү, сүүн бүтээгдэхүүний жилийн хэмжээ 2020 онд 124.1 кг болж, 2019 онтой харьцуулахад 3.5%-иар өссөн дүнтэй байна.

## Хөдөө аж ахуйн сүү татан авалт:

“Сүү” ХК-ийн хувьд 2018 онд мөнгөн дүнгээр 17.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нийт 19.3 сая литр үнээний сүү, 2019 онд мөнгөн дүнгээр 18.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нийт 20,2 сая литр үнээний сүү гэрээт малчид, фермерүүдээс татан авсан бөгөөд энэ нь томоохон сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчдийн татан авсан нийт сүүний 50 орчим хувьтай тэнцэж байна. Дээрх үзүүлэлт нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48%-иар өссөн үзүүлэлт бөгөөд цаашид энэ үзүүлэлт жилд дунджаар 15%-иар өсөх хандлага ажиглагдаж байгаа юм.

Монгол улсын сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч томоохон компаниуд 2019 онд ХАА-аас нийт 49.2 сая литр сүү татан авч боловсруулснаас 44% буюу 20.2 сая литр сүүг “Сүү” ХК дангаараа хүлээн авч боловсруулан, зах зээлд нийлүүлсэн байна.

## 6. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн тархалтын судалгаагаар “Сүү” ХК нь нийт 2,562 хувьцаа эзэмшигчтэй байна. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч<sup>1</sup> нь Д.Ганбаатар, Д.Жамъян, Д.Уянгалянхуа нар юм.

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо, хувь эзэмшил /хувьцаа нэмж гаргахын өмнөх байдлаар/	Хувьцаа нэмж гаргасны дараах байдлаар /Энгийн хувьцааны 25% хүртэлх хувьтай тэнцүү хэмжээтэй буюу хамгийн дээд боломжит хэмжээгээр гаргасан нөхцөлөөр төсөөлөв/
Д.Ганбаатар	113,730,000 ширхэг 33.06%	113,730,000 ширхэг 26.5%
Д.Уянгалянхуа	72,240,000 ширхэг 21.00%	72,240,000 ширхэг 16.8%
Д.Жамъян	133,103,000 ширхэг 38.7%	133,103,000 ширхэг 31.0%
<b>Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид</b>	<b>92.75%</b>	<b>74.3%</b>
Бусад хувьцаа эзэмшигчид	24,927,000 ширхэг 7.2%	110,516,000 ширхэг 25.7%
Нийт	100%	100%

## 7. Нэмж гаргах хувьцааны талаар:

7.1. “Сүү” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 25% хүртэлх хувьтай тэнцүү хэмжээний хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэн, улмаар Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэгт Хувьцаа эзэмшигчдын хурлаар “Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох” эрхтэй гэж заасны дагуу 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа нэмж гаргах тухай асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

<sup>1</sup> “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 4.1.29. “Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг;

“Сүү” ХК нь нэмж үнэт цаас гаргах төсөл, түүнтэй холбоотой компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэх юм. “Монголын хөрөнгийн бирж” ХК нь хувьцаа нэмж хувьцаа гаргах буюу үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг хянаж, бүртгэлийн шийдвэр гарсны дараа Монгол улсын Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтийг хүргүүлж шийдвэрлүүлнэ. Санхүүгийн зохицуулах хорооноос “Сүү” ХК-ийн нэмж гаргах хувьцааг бүртгэсэнээр, нэмэлт хувьцаа гаргах ажиллагаа хэрэгжиж эхэлнэ.

## 7.2. Нэмж гаргах хувьцааны талаар:

<b>“Сүү” ХК-ийн энгийн хувьцаа</b>	<b>Тоо ширхэг</b>	<b>Хувь</b>
Гаргасан буюу эргэлтэнд байгаа хувьцааны тоо	344,000,000	80.00%
Нэмж гаргах хувьцаа /Энгийн хувьцааны 25% хүртэлх хувьтай тэнцүү хэмжээтэй буюу хамгийн дээд боломжит хэмжээгээр гаргасан нөхцөлөөр төсөөлөв/	85,589,000	20.00%
<b>Хувьцаа нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо</b>	<b>429,589,900</b>	<b>100%</b>

7.3. Нэмж гаргах хувьцааны үнийн мэдээлэл: “Сүү” ХК-ийн нэмж гаргах хувьцааны үнийг компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөлд нэмж гаргаж буй хувьцааны үнэ, түүнтэй холбоотой шийдвэр гаргах эрхийг олгохоор хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөлд тусгаад байна.

## 8. “Сүү” ХК нь хувьцаа нэмж гаргах шийдвэртэй холбоотой хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх тухай:

8.1. Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй тухай:

Хувьцаа эзэмшигчдэд нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс саналыг оруулж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн, уг асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

8.2. Компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх:

“Сүү” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг олон нийтэд, нээлттэй хүрээнд гаргах шийдвэр гарсантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.2 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 87.1.1 болон 87.1.2 дахь хэсгүүд, 88 дугаар зүйлийн 88.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигч нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүсэхгүй. Шинээр нэмж гаргах хувьцааны тоо нь компанийн урьд гаргасан хувьцааны 25%-д хүрэхгүй тул их хэмжээний хэлцэлд тооцогдохгүй болно.

## **9. Компани нэмж хувьцаа гаргах ажиллагааг дуусгавар болгох:**

9.1. "Сүү" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, андеррайтер болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хувьцаа эзэмшигчдээс олгогдсон эрхийн дагуу нэмж хувьцаа гаргах ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

9.2. Компанийн хувьцаа нэмж гаргах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталснаар "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон Монгол улсын Санхүүгийн зохицуулах хороонд нэмж гаргаж буй хувьцааг бүртгүүлэх, нэмж гаргаж буй хувьцааг олон нийтэд, нээлттэй хүрээнд санал болгон арилжаалж, шаардлагатай санхүүжилтийг татах ажиллагааг дуусах хүртэл бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

9.3. Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооноос нэмж хувьцаа гаргахыг зөвшөөрсөн шийдвэр гарсан өдрөөс эхлэн нэмэлт хувьцаагаа олон нийтэд сурталчлах, хувьцааг Монголын хөрөнгийн биржээр арилжаалж, компани нэмж хувьцаа гарган шаардлагатай санхүүжилтыг татан төвлөрүүлж, хувьцааны арилжааны тайланг холбогдох байгууллагуудад гаргах, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, компанийн дүрэмд орсон өөрчлөлтүүдийг холбогдох төрийн захиргааны байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлснээр нэмж хувьцаа гаргах үйл ажиллагаа дуусгавар болно.

-----oOo-----

# “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04-р сарын 17-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

## НЭМЖ ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХГҮЙ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг болон “Сүү” ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын №02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн нэмж гаргаж буй 85,589,000 ширхэг хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг тус компанийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ